

БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

(Мэдээлэл, лавлагаа)

Д.Халиун

Бүгд Найрамдах Ирланд Улс нь 1937 оны 7 сарын 1-нд баталсан Үндсэн хуулиа тус оны 12 сарын 29-ны өдрөөс эхлэн бүх нийтээрээ дагаж мөрдөж ирсэн.

Хууль тогтоох дээд байгууллага нь Ерөнхийлөгч, Төлөөлөгчдийн болон Сенатын танхимаас бүрдэх Вестминстерийн загвар¹⁹⁹ бүхий Парламент юм. Төлөөлөгчдийн танхимын 166 гишүүн (ирэх сонгуулиар 158 болгон бууруулах гэж буй)-ийг бүх нийтийн сонгуулиар сонгодог. Харин Засгийн газрын тэргүүний нэр дэвшүүлсэн 11, Үндэсний болон Дублины Их сургуулиас сонгогдсон 6 төлөөлөгч, тусгай 5 салбараас нэр дэвшүүлсэн 43 (улсын болон орон нутгийн) нийт 60 гишүүнтэй Сенатын танхим 7 жилийн хугацаатай бүрэн эрхээ хэрэгжүүлдэг.²⁰⁰

2017 онд Парламентын төсвийн алба байгуулагдсанаар Ирландад “Бие даасан төсвийн институт (Independent Fiscal Institution)” буюу төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан, хараат бус 2 байгууллагатай болсон.²⁰¹ Эдгээр нь:

- Ирландын Төсвийн зөвлөх зөвлөл - **Irish Fiscal Advisory Council** (2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан)
- Парламентын төсвийн алба - **Parliamentary Budget Office**²⁰² (2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан)



БҮГД НАЙРАМДАХ ИРЛАНД УЛСЫН ТӨСВИЙН ЗӨВЛӨХ ЗӨВЛӨЛ (Irish Fiscal Advisory Council (IFAC))

Байгуулагдсан: 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр.
(2011 оноос байнгын бус үйл ажиллагаа явуулж байсан)

Байгуулсан эрх зүйн акт: 2012 онд батлагдсан Төсвийн хариуцлагын тухай хууль - Fiscal Responsibility Act 2012 (FRA).²⁰³

Төсөв: EUR 800 000 (Төсвийн хариуцлагын тухай хуулиар тогтоосон).

Орон тоо: Зөвлөлийн гишүүн, дарга - 5 (part-time буюу орон тооны бус) болон байнгын ажиллагаатай ажлын алба (full-time secretariat) - 7 албан хаагч.

Зөвлөлийн гишүүдийг Сангийн сайд 4 жилийн хугацаагаар томилно.

Зөвлөлийн дарга:

- 2016-оноос эдийн засагч Симус Коффи (Seamus Coffey) (University College Cork).
- 2011-2016 он Профессор Джон МакХэйл (National University of Ireland Galway).

¹⁹⁹Парламентын дээд танхим нь төсөвтэй холбоотой асуудлаар харьцангуй хязгаарлагдмал эрх үүрэгтэй байна.

²⁰⁰<https://www.oecd.org/gov/budgeting/Review-of-budget-oversight-by-parliament-Ireland.pdf>

Source: Oireachtas Library and Research Service (2011), www.oireachtas.ie/parliament, www.president.ie, <http://per.gov.ie/public-expenditure>

²⁰¹Дээрх 2 байгууллага нь нэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэдий ч хоорондоо ялгаатай чиг үүрэг, зорилго, статустай байна. Парламентын төсвийн алба нь Парламентын болон түүний хороодод дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх ба дээрх 2 байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг давхцуулахгүй байхад онцгой анхаарч, байгууллагын удирдлагууд цаашид хамтран ажиллах тал дээр тогтмол уулзалт зохион байгуулдаг. Зарим улсад, тухайлбал, Австрид ПТА-ны дарга нь Австрийн Төсвийн зөвлөлийн хуралд санал өгөх эрхгүйгээр оролцдог.

²⁰²Ireland's Parliamentary Budget Office (PBO) was established (on 15th August 2017) within the Houses of the Oireachtas as part of the process of Dáil reform. A commitment in relation to its establishment was also made in the Programme for a Partnership Government. The PBO is one of the specialist units which have been established in recent years within the Houses of the Oireachtas Service. These include the Office of the Parliamentary Legal Advisor and the Library & Research Service (L&RS).

²⁰³https://data.oireachtas.ie/ie/oireachtas/parliamentaryBudgetOffice/2017/2017-11-24_the-role-and-functions-of-ireland-s-parliamentary-budget-office_en.pdf

ЕХ/ОУВС-аас Ирландад үзүүлэх санхүүгийн дэмжлэг болон 2011 оны Засгийн газрын Хөтөлбөр зэргийн хүрээнд явагдсан төсвийн шинэтгэлийн хүрээнд 2012 онд батлагдсан Төсвийн хариуцлагын тухай хуулиар Төсвийн зөвлөх зөвлөлийг байгуулсан.

Ирландын Төсвийн зөвлөх зөвлөл нь төсвийн төсөөлөл, төсвийн бодлогын чиглэлээр бие даасан, хараат бусаар шинжилгээ хийх зорилго бүхий бие даасан байгууллага юм.

2013 оны 7-р сарын ЕХ-ны тогтоолыг²⁰⁴ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Төсвийн Зөвлөх зөвлөлийн чиг үүрэгт улсын төсвүүд болон Тогтвортой байдлын хөтөлбөрүүдийн суурь болох Сангийн яамнаас бэлтгэдэг макро эдийн засгийн төсөөллийг үнэлэх, баталгаажуулах чиг үүргийг нэмж тусгасан. Энэхүү нэмэлт чиг үүрэгтэй холбоотой зохицуулалтыг Төсвийн зөвлөх зөвлөл болон Сангийн яам хооронд байгуулсан санамж бичгээр (2018 оны 1-р сарын 30-ны өдөр) зохицуулсан.

Төсвийн зөвлөх зөвлөлийн чиг үүрэг

- Төсөв болон Тогтвортой байдлын хөтөлбөрийн үндэс, суурь болох Сангийн яамнаас бэлтгэсэн макро эдийн засгийн төсөөллийг зохистой гэж үзсэний үндсэн дээр баталгаажуулах.
- Сангийн яамнаас гаргасан албан төсөөлөлд дүн шинжилгээ хийх. Сангийн яамнаас Тогтвортой байдлын хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар - хавар, төсвийн төсөл – намар тус тус гаргадаг байна.
- Засгийн газрын төсвийн санхүүжилт нь ЕХ-ны Тогтвортой байдал ба Өсөлтийн гэрээтэй холбоотой эдийн засаг, төсвийн удирдлагын зохистой удирдлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх.
- Төсвийн хариуцлагын тухай хуулиар тогтоосон шаардлага, төсвийн дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих. “Төсвийн дүрэм”-д зааснаар төсөв алдагдалгүй, эсхүл тэнцвэртэй байх буюу алдагдалгүй, тэнцвэртэй байхад чиглэсэн байх юм.
- Төсвийн дүрэм зөрчигдсөн нь Засгийн газраас үл хамаарах онцгой нөхцөл байдал үүссэн, эдийн засгийн уналт зэргээс төсөвт нөлөөлсөн эсэхийг тогтоох үүрэгтэй байна.
- Төсвийн зөвлөх зөвлөлийг дээрх чиг үүргээ бие даан, хараат бусаар гүйцэтгэхэд хуулиар баталгаажуулна.
- Төсвийн зөвлөлийн зөвлөл нь жилд хоёр удаа “Төсвийн үнэлгээний тайлан”, жилд нэг удаа Төсвийн урьдчилсан мэдэгдэл гарган Сангийн сайдад хүргүүлж, 10 хоногийн дотор олон нийтэд нийтэлнэ. Засгийн газар нь Төсвийн зөвлөх зөвлөлийн төсвийн холбогдох дүрэм журамд нийцэж буй эсэхэд хийсэн үнэлгээний тайланг хүлээн аваагүй бол Сангийн сайд Парламент (доод танхим)-д хүлээн аваагүй шалтгааныг тусган мэдүүлнэ.

²⁰⁴REGULATION (EU) No 473/2013 OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL of 21 May 2013 on common provisions for monitoring and assessing draft budgetary plans and ensuring the correction of excessive deficit of the Member States in the euro area
<https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2013:140:0011:0023:EN:PDF>

Төсвийн зөвлөх зөвлөл нь макро эдийн засаг, төсвийн бодлогод чиглэдгийн хувьд Засгийн газраас Парламентад өргөн барьсан төсвийн жил бүрийн зарлагын задаргаа, шинээр оруулж ирж буй төсвийн бодлогын асуудлаар оруулж ирж буй шинэ санал тус бүрийг хянан, шинжилгээ хийдэггүй.

Ирландын Төсвийн Зөвлөх зөвлөлийн чиг үүрэгт (Австрали, Канад, Нидерланд зэргийн ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагын чиг үүрэгт байдагтай адил) бодлогын төслүүдийн нарийвчилсан зардлыг гаргах, үүнд улс төрийн янз бүрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд, эсхүл шинэ Засгийн газар, эвслийн аливаа санал санаачилга бодлого нь төсвийн тэнцэлд хэрхэн тусгагдаж, эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь ямар байхыг тооцох зэрэг чиг үүргийг хүлээдэггүй. Зөвлөл нь шинжилгээний тайлан, ажлын баримт бичгийг өөрийн санаачилгаар олон нийтэд зориулан нийтэлдэг байна.

Хууль тогтоох байгууллагатай хэрхэн харилцдаг тухай

ИТЗЗ нь үйл ажиллагаагаа Засгийн газар болон Парламентаас хараат бусаар явуулах боловч Сангийн сайд зөвлөлийн гишүүдийг томилно. Мөн тэрээр холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр Парламентын доод танхимын зөвшөөрснөөр зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, огцруулна. ИТЗЗ нь ажилтан авах, байр түрээслэх зэрэгт Сайдын зөвшөөрлийг (Төрийн зардал, шинэтгэлийн сайд (Minister for Public Expenditure and Reform)-тай зөвшилцөн) урьдчилан авсан байна.

Төсвийн хариуцлагын тухай хуульд заасны дагуу ИТЗЗ нь үйл ажиллагааны тайлангаа жил бүр Сайдад хүргүүлэх ба Сайд хуулбарыг “боломжтой болмогц” Парламентад хүргүүлнэ (13-р зүйл). Ерөнхий хянан шалгагчийн алба болон Ерөнхий аудитор нь парламентад хүргүүлсэн ИТЗЗ-ийн санхүүгийн тайланд аудит хийнэ (10-р зүйл). Парламентын доод танхим нь ИТЗЗ-ийн даргаас холбогдох нотлох баримт шаардаж болох ба 2 танхимын хороод нь ИТЗЗ-ийн үйл ажиллагааг тайлагнахыг ИТЗЗ-ийн даргаас хүсэж болно (11-р зүйл).

ИТЗЗ нь үйл ажиллагаагаа явуулахад Сангийн яамны ашиглаж буй загварчлал, аргыг мэдэж байх шаардлагатай байдгаас гадна ИТЗЗ нь Сангийн яам, Төв Статистикийн газар, Үндэсний төрийн сангийн агентлаг зэрэг байгууллагаас гаргаж буй мэдээллээс ихээхэн хамааралтай байдаг. Иймд ИТЗЗ нь зарим байгууллагатай статистикийн болон бусад мэдээллийн зохистой урсгал бий болгох тал дээр санамж бичиг байгуулах нь зүйтэй гэсэн санал гаргасан. ИТЗЗ нь Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэнтэй нягт хамтран ажилладаг.

Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө

Төсвийн зөвлөх зөвлөл нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын төлөвлөгөөгөө өөрөө боловсруулан баталдаг. Зөвлөл нь гол төлөв сард нэг удаа цугладаг, ихэнх ажлаа утсаар, эсхүл и-мэйлээр гүйцэтгэдэг. Гол ажлууд нь Сангийн яамнаас гаргасан албан төсөөлөлд дүн шинжилгээ хийх.

Сангийн яамнаас Тогтвортой байдлын хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар - хавар, төсвийн төсөл - намар тус тус гаргадаг байна. ИТЗЗ нь мэргэжлийн шинжээч, экспертүүдийг гэрээгээр авч ажиллуулж болдог.

Төсөв

2011-2012 онд ИТЗЗ нь Засгийн газрын буцалтгүй тусламжаар санхүүжиж, 2012 онд EUR 650 000 төсөвтэй байсан бол 2013 онд ИТЗЗ-ийн төсвийн дээд хэмжээг Төсвийн хариуцлагын тухай хуулиар EUR 800 000 байхаар тогтоосон ба жил бүр инфляцын хэмжээтэй уялдуулан индексжүүлж тооцно. ИТЗЗ-ийн төсөв ("non-voted" expenditure)-ийг хуулиар тогтоосон байх ба Засгийн газраас санал оруулж, Парламент батлах шаардлагагүй байдаг нь томоохон хамгаалалт болдог байна. Холбогдох тайлангуудад дээрх санхүүжилтийн хэмжээ нь үйл ажиллагаа явуулахад хангалттай, хүрэлцэхүйц гэж дурдсан байна.

Удирдлага, бүтэц

ИТЗЗ-ийн 5 гишүүнийг Сангийн сайд томилж, мөн тэрээр гишүүд дундаас даргыг сонгоно. Зөвлөлийн гишүүн улс төрийн алба хашихыг хориглоно. Гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх ба нэг удаа улируулан ажиллуулж болно. Энэ нь парламентын бүрэн эрхийн 5 жилийн хугацаатай зөрүүлж тогтоосон хугацаа юм.

Зөвлөлийн гишүүнийг хугацаанаас нь өмнө Сангийн сайд гагцхүү Парламентын доод танхимын тогтоолд Төсвийн хариуцлагын тухай хуульд заасан дараах үндэслэлийг дурдсаны үндсэн дээр чөлөөлж болно. Үүнд:

- а) гишүүн нь эрүүл мэндийн шалтгаанаар чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх чадваргүй болсон;
- б) гишүүн нь зүй бус үйлдэл үйлдсэн (misbehaviour);
- в) тухайн гишүүн нь сонирхлын зөрчилтэй гэж сайд үзсэн; эсхүл
- г) гишүүнийг огцруулах нь ИТЗЗ-ийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн зэрэг байна.

Мөн гишүүнийг дараах үндэслэлээр огцруулж болно:

- а) дампуурлаа зарласан;
- б) зээлдүүлэгчтэй (үүрэг гүйцэтгүүлэгчтэй) харилцан тохиролцсон хэлэлцээр, тохиролцоо хийсэн;
- в) гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн;
- г) залилан буюу шударга бус үйл ажиллагаатай холбоотойгоор зөрчил үйлдсэн; эсхүл
- е) 1990 оны Компанийн тухай хуулийн 150-р зүйлийг зөрчсөн (4-р зүйл [4]).²⁰⁵

²⁰⁵has a declaration under Section 150 of the Companies Act 1990 made against him or her or is subject or is deemed to be subject to a disqualification order by virtue of Part VII of that Act. (Article 4[4]).

Дээрхээс гадна гишүүн нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж болно.

2011 онд байгуулагдсан зөвлөлийн бүтэц нь эдийн засаг, төрийн санхүүгийн чиглэлээр мэргэшсэн, Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэн, ОУВС, ЭЗХХАБ зэрэг нэр хүндтэй олон улсын байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүмүүсээс бүрдсэн.

Зөвлөлийн гишүүн нь Ирландын иргэн байх шаардлагагүй байх ба 2011 оны анхны бүтцэд Ирландын иргэн бус 1 гишүүн ажиллаж байсан ба 5 гишүүний 3 нь гадаадад байрлаж байсан. Дээрхийг зөвлөлийн үйл ажиллагааг илүү бодитой, үр дүнтэй болгоно гэж үзсэн байна.

ИТЗЗ-ийн гишүүд нь орон тооны бус хэдий ч, ажлын ачаалал өндөр зэргийг харгалзан орон тооны албан хаагчтай адил цалинжуулах зарчмыг баримталдаг. ИТЗЗ-ийн даргын жилийн цалин EUR 20 520 байх бол гишүүний цалин EUR 11 970 байна.

Анх ИТЗЗ-ийн ажлын алба нь 3 ажилтантай байсан бол өдгөө 7 болон нэмэгдсэн. Ажлын албаны ажилтнуудыг сэлгэн ажиллуулах журмаар ажиллуулдаг. (Тухайлбал, Төв Банк, Үндэсний төрийн сангийн агентлаг, Төрийн зардал, шинэтгэлийн яам болон Эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэн зэргээс) Хэдийгээр төсөв санхүүгийн хувьд ИТЗЗ нь ажлын албаны ажилтныг ажиллуулахад хүндрэл гаргадаггүй бол дээр дурдсанчлан Сангийн сайдаас урьдчилан зөвшөөрөл авдаг нь (ажилтан тус бүрд бус, орон тооны хувьд) зохион байгуулалтын хувьд төдийлөн хараат бус байж чадахгүй байна.

ПАРЛАМЕНТЫН ТӨСВИЙН АЛБА²⁰⁶
(Parliamentary Budget Office (PBO))

Байгуулагдсан: 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр.

Төсөв: EUR 960 000 (2018 онд төлөвлөсөн).

Орон тоо: 15-төлөвлөсөн.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

²⁰⁶ГТА нь сүүлийн жилүүдэд явагдсан Парламентын шинэтгэлийн хүрээнд байгуулагдсан нэгжийн нэг бөгөөд үүнээс гадна Парламентын хуулийн зөвлөхийн алба, Номын сан, судалгааны алба зэрэг тус тус байгуулагдсан байна.

ИРЛАНДЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

